



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 сарын 31 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **“21 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа**

21.1. Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.

21.2. Авлигатай тэмцэх газар дэд даргатай байна. Дэд даргыг Авлигатай тэмцэх газрын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.

21.3. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга энэ хуулийн 19.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

21.3.1. Авлигатай тэмцэх газрын дарга төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, 45 нас хүрсэн, эрх зүйч мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;

21.3.2. Авлигатай тэмцэх газрын дэд дарга төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын мэдлэг, туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.

21.4. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг нэг удаа улируулан томилж болно.

21.5. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн дарга, дэд дарга томилогдсоноор дуусгавар болно.

21.6. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 21.1, 21.2-т заасан бүрэн эрхийн үлдсэн хугацааг дуустал үргэлжилнэ.”

**2 дугаар зүйл.** Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг” гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР